

МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЭЛ, ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБОО ТЕХНОЛОГИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо
технологийн газрын Бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн
Ж.Баатархүү

Агуулга:

1. Мэдээл, шуудан, харилцаа холбоо технологийн салбарын үйл ажиллагаанд хэрэглэгддэг хууль
2. Монгол Улсын Мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал/ УИХ-ын 2000 оны 21 дүгээр тогтоолын хавсралт/
3. Төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүд
4. Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэнд хийсэн хяналт шинжилгээ
5. Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбоо технологийн талаар төрөөс баримтлах бодлого/шинэ/

МОНГОЛ

УЛСЫН

ХУУЛИУД:

1. Харилцаа холбооны тухай -2001 он
2. Радио долгионы тухай -1999 он
3. Шуудангийн тухай - 2003 он
4. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай - 2001 он
5. Засгийн газрын тусгай сангийн тухай - 2006 он
6. Өрсөлдөөний тухай - 2010 он
7. Зар сурталчилгааны тухай - 2002 он
8. Концессын тухай - 2010 он

Монгол Улсын Мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал/ УИХ-ын 2000 оны 21 дүгээр ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

Энэхүү үзэл баримтлалын эрхэм зорилго нь мэдлэг оюунд тулгуурласан нийгмийг хөгжүүлж, ард түмний амьдралын чанарыг сайжруулах бөгөөд 3 үндсэн зорилгын хүрээнд нийтдээ үйл ажиллагааны 58 заалтууд тусгагдсан байна. Үүнд:

Төр эрх зүйн хүрээнд төр нь мэдээлэлжсэн нийгмийн тогтолцоог бүрдүүлэгч, мэдээллийн нээлттэй эх үүсвэрээр хангагч үндсэн үйлчлэгч болох үндсэн зорилгын дор мэдээлэл холбооны технологийн хөгжлийн эрх зүйн таатай орчинг бүрдүүлж төлөвшүүлэх, мэдээллийн бодлого зохицуулалтын тогтолцоог бий болгох, төрийн мэдээллийн тогтолцоог мэдээлэл, холбооны технологиор дэмжин хөгжүүлэх;

Эдийн засаг-бизнесийн хүрээнд мэдээлэл, холбооны технологийн бизнесийг өргөжүүлж, өндөр үр ашигтай эдийн засгийн салбар болох, эдийн засаг-бизнесийн үр ашигтай, шуурхай мэдээллийн тогтолцоог бий болгох, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээнд мэдээлэл холбооны технологийг эрчимтэй нэвтрүүлэх;

Эдийн засаг-бизнесийн хүрээнд мэдээлэл, холбооны технологийн бизнесийг өргөжүүлж, өндөр үр ашигтай эдийн засгийн салбар болох, эдийн засаг-бизнесийн үр ашигтай, шуурхай мэдээллийн тогтолцоог бий болгох, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээнд мэдээлэл холбооны технологийг эрчимтэй нэвтрүүлэх;

Хүний хөгжлийн хүрээнд мэдээллийн үйлчилгээгээр дамжуулан иргэд нийгмийн харилцаанд идэвхтэй, эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх, иргэд мэдээллийг чөлөөтэй олж авах тогтолцоог бий болгох, нийгмийн үйлчилгээнд мэдээллийн технологийг өргөнөөр хэрэглэх.

Төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүд

1. Монгол Улсын мэдээлэл, холбооны салбарын бодлого, зохицуулалтын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн үзэл баримтлал,
2. Монгол Улсын улс, хот хооронд, орон нутгийн мэдээлэл, холбооны нэгдсэн сүлжээг хөгжүүлэх концепц
3. Радио телевизийн хөгжлийн бодлогын хөгжлийн бодлогын баримт бичиг

4. Мэдээллийн технологийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт
5. Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний болон харилцан холболтын үнэ тарифын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн үзэл баримтлал
6. Монгол Улсын Шуудангийн салбарын хөгжлийн үзэл баримтлал
7. Шуудангийн салбарын хөгжлийн дунд хугацааны бодлогын хөтөлбөр
8. “Цахим Монгол Үндэсний хөтөлбөр”
9. Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр -2008 он

10. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр

11. Радио телевизийн өргө нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр

12. Өрх бүрт шуудан үндэсний хөтөлбөр

13. Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл

14. Монгол Улсад хөдөлгөөнт телевизийн үйлчилгээг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл

15. Монгол Улсад интернет протоколд суурилсан телевиз/IPTV/-ийн үйлчилгээг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл

16. . Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо технологийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр

16. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо технологийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр

17. Мэдээллийн технологийн гадаад аутсорсингийг 2015 он хүртэл хугацаанд хөгжүүлэхэд баримтлах чиглэл

18. Өртөг нэмэгдүүлэх үйлчилгээний зориулалт бүхий тусгай дугаарын талаар баримтлах чиглэл

19. Монгол Улсад утасгүй холболтын системийг нэвтрүүлэх талаар баримтлах чиглэл

20. Монгол Улсад утасгүй суурин холбооны /WLL/ технологийг нэвтрүүлэх талаар баримтлах чиглэл

21. Монгол Улсад хөдөлгөөнт холбооны GSM системийг нэвтрүүлэх талаар баримтлах чиглэл

22. Монгол Улсад хөдөлгөөнт холбооны CDMA-450 системийг нэвтрүүлэх талаар баримтлах чиглэл

23. Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 3 дахь үеийн системийг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл

Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэнд хийсэн хяналт шинжилгээ

- Үзэл баримтлалын зорилго, зорилт бүрийн хэрэгжилтийг цуглуулсан мэдээлэлд тулгуурлаж тоймлон гаргасан.
- Цахим Монгол хөтөлбөр, МХТ-ийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний зорилго зорилттой харьцуулсан.
- Тус газрын даргын тушаалаар батлагдсан “МШХХТ-ийн салбарын төсөл, хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, ЗГ-ын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан хяналт-шинжилгээний журмын аргачлалаар хэрэгжилтийн явц, хувийг тодорхойлсон.

Суурь мэдээ: Цахим монгол хөтөлбөрийн биелэлт, МХТ-ийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний биелэлт, Албан бичгээр СЯ, НХХЯ, ЭБЭХЯ, ХХАҮЯ, ХЗДХЯ, ШУА, БСШУЯ, ЭМЯ, СХҮГ-ээс биелэлтийг гаргуулсан. Дэд бүтцийн яамны 1996 оноос хойшхи товхимлууд, өмнө гарсан судалгааны тайлан, холбогдох баримт бичгийн эх сурвалжууд

Үзэл баримтлал, стратеги төлөвлөгөө, Цахим Монгол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (хувь)

- МХТ-ийн хөгжлийн 2010 хүртэлх үзэл баримтлалын биелэлт, хувь хэмжээгээр (2010 оны 7-р сарын байдлаар) 90.2
- МХТ-ийг дунд хугацаанд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний биелэлт, хувь хэмжээгээр (2010 оны 7-р сарын байдлаар) 86,3
- Цахим Монгол Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хувь хэмжээгээр (2010 оны 4-р сарын байдлаар) 70,6

Үзэл баримтлалын зорилгын хэрэгжилт

№	Зорилгууд	Биелэлт,%
1	Мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн эрх зүйн таатай орчин бүрдүүлж, төлөвшүүлэх, (6)	85
2	Мэдээллийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох , (13)	100
3	Төрийн мэдээллийн тогтолцоог мэдээлэл, холбооны технологиор дэмжин хөгжүүлэх, (7)	87
4	Мэдээлэл, холбооны технологийн бизнесийг өргөжүүлж, өндөр үр ашигтай эдийн засгийн салбар болгох, (7)	88
5	Эдийн засаг-бизнесийн үр ашигтай, шуурхай мэдээллийн тогтолцоог бий болгох, (5)	100
6	Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээнд мэдээлэл, холбооны технологийг эрчимтэй нэвтрүүлэх, (3)	100
7	Мэдээллийн үйлчилгээгээр дамжуулан иргэд нийгмийн харилцаанд идэвхтэй, эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх, (4)	87
8	Иргэд мэдээллийг чөлөөтэй олж авах тогтолцоог бий болгох , (5)	75
9	Нийгмийн үйлчилгээнд мэдээлэл, холбооны технологийг өргөн нэвтрүүлэх, (8)	90

Үзэл баримтлалын үнэлгээ, үзүүлэлт

100 хүн тутамд

дд	МХХТ-ийн үзүүлэлт	2010	2012	2015	2021
1	Суурин телефон хэрэглэгчийн тоо: - МХХТ-ийн үзэл баримтлалд - Цахим Монгол хөтөлбөрт - Үндэсний хөгжлийн стратегид	7.0 - - -	 15* -	 10**	 -
2	Үүрэн телефон хэрэглэгчийн тоо: - МХХТ-ийн үзэл баримтлалд - Цахим Монгол хөтөлбөрт - Үндэсний хөгжлийн стратегид	92.5 - - -	 20* -	 35**	 -
3	Интернэтийн хэрэглэгчийн тоо: - - МХХТ-ийн үзэл баримтлалд - Цахим Монгол хөтөлбөрт - Үндэсний хөгжлийн стратегид	6.5 - - -	 10* -	 3**	 -
4	Компьютерийн тоо: - - МХХТ-ийн үзэл баримтлалд - Цахим Монгол хөтөлбөрт - Үндэсний хөгжлийн стратегид	9.2 - - -	 20 -	 -	 -

Хураангуй дүгнэлт

- Энэхүү үзэл баримтлал нь Монгол Улсын мэдээлэл харилцаа холбооны 10 жилийн хөгжлийн бодлогыг тодорхой баримжаалж, чиглүүлж чадсан чухал бодлогын баримт бичиг юм.
- Үзэл баримтлалд 3 чиглэл 9 стратегийн зорилго, 58 зорилт дэвшүүлсэний 29 нь биелсэн, 28 нь 70-аас дээш хувь, 1 зорилт 50 хувь хэрэгжиж байгаа буюу 2010 оны II улирлын байдлаар 90.2% буюу хангалттай хэрэгжсэн байна.
- Цаашид мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн 2021 он хүртэлх бодлогын баримт бичгийг Үндэсний хөгжлийн цогц бодлого, бусад салбарын бодлоготой уялдуулан боловсруулж УИХ-аар батлуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хураангуй дүгнэлт

- Үзэл баримтлалд тусгагдсан Мэдээллийн технологийн хуулиудыг батлуулж гаргах, цахим засаглалыг хөгжүүлэх, МХХТ-ийн бүх нийтийн боловсрол олгох зэрэг ажлуудыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Цаашид салбар хоорондын уялдааг хангах нэгдсэн удирдлага, зохицуулалт бүхий Үндэсний хороог шинэчлэх саналыг тус газраас ЗГХЭГ-т оруулаад байна. Түүнчлэн салбарын судалгаа шинжилгээний төв байгуулж, мэдээлэл, холбооны хөгжлийн түвшинг тодорхойлох, ирээдүйн төлөвлөлтөд гадаад, дотоод хүчин зүйлийг /ядуурал, инфляци, дэлхийн дулаарал г.м/ тооцох шаардлагатай байна.

Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбоо технологийн талаар төрөөс баримтлах бодлого/шинэ/

“Монгол улсын Мэдээлэл, харилцаа холбоо технологийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийг боловсруулахын тулд Мэдээлэл, харилцаа холбооны технологи/цаашид МХХТ гэх/-ийг нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд түгээн дэлгэрүүлж, хөгжүүлснээр улс орныхоо хөгжлийг хурдасгаж байгаа дэлхийн нийт улс, үндэстний нийтлэг чиг хандлагыг тодорхойлсон Дэлхийн цахилгаан холбооны байгууллагаас Дэлхийн мэдээлэлжсэн нийгмийн Дэлхийн дээд хэмжээний 2005 оны чуулганаас дэвшүүлсэн дунд хугацааны зорилтуудын биелэлтэнд 2010 онд хийсэн хяналт шижилгээ, 2015 он хүртэл дэвшүүлсэн 10 зорилт, Европын холбооны орнуудын МХХТ-д хийсэн хяналт шинжилгээ, Япон, БНСУ, Гана, Тайланд, Кени, Канад зэрэг улсуудын МХХТ-ийн талаарх төрийн бодлого, “Монгол Улсын Мянганы хөгжлийн Зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, түүнийг үндэслэн боловсруулсан Биеийн тамир спорт, Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги, Төмөр зам зэрэг салбаруудын төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдийг судалж, танилцсан болно.

“Монгол улсын Мэдээлэл, харилцаа холбоо технологийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын төсөл боловсруулах ажлыг:

- “Монгол улсын Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”/УИХ-ын тогтоолоор батлуулах/
-Харилцаа холбоо, Шуудан, Өргөн нэвтрүүлэг, Мэдээллийн технологийн өнөөгийн байдал, хүрсэн түвшин, тулгамдсан асуудал, бодлого, стратегийг хамарсан бодлогын судалгаа гэсэн 2 чиглэлээр салбарын төрийн захиргаа, зохицуулах байгууллага, гол оролцогч байгууллагуудын мэргэжилтнүүд Их дээд сургуулиудын эрдэмтэн судлаачид оролцсон 50 гаруй хүн гүйцэтгэв.

Бодлогын баримт бичгийн бүтэц, үзэл санааг “Монгол Улсын Мянганы хөгжлийн Зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын баримт бичигт **“Мэдээлэл, харилцаа холбооны технологийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 21 дүгээр зууны үндсэн хурдасгуур гэж үзнэ”** гэсэн бодлогын томъёолол, Монгол Улсын “Мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал”-д хийсэн хяналт-шинжилгээ, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн 2000-2010 онд хүрсэн хөгжлийн түвшин, сургамж, тулгамдсан асуудлуудын талаар Харилцаа холбоо, Шуудан, Өргөн нэвтрүүлэг, Мэдээллийн технологийн чиглэлээр боловсруулсан судалгааг үндэслэн боловсруулав.

Баримт бичгийн эхний хувилбар болох “Монгол улсын Мэдээлэл, харилцаа холбоо технологийн талаар 2021 он хүртэл төрөөс баримтлах бодлого” гэсэн төслийг 2011 оны 5 сарны 25-26-ны өдрүүдэд Төрийн ордонд зохион байгуулсан Мэдээлэл, харилцаа холбооны улсын зөвлөгөөнөөр хэлэлцүүлсэн болно. Уг зөвлөгөөнд манай улсын Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн салбарын болон бусад төр, олон нийт, аж ахуйн байгууллагын 1000 шахам төлөөлөгчид оролцож, Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэлэлцэн, сайшаан дэмжиж, түүнтэй холбогдуулан 100 гаруй хүн амаар буюу бичгээр гаргасан 200 гаруй санал, Олон Улсын цахилгаан холбооны байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, байгууллагын Вэб хуудсаар дамжуулж болон бусад хэлбэрээр зарим иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, зөвлөмжүүдийг нэг бүрчлэн судалсны

үндсэн дээр бодлогын баримт бичгийг “Монгол улсын Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн талаар төрөөс баримтлах бодлого” болгон, шинэчлэн найруулж, боловсруулаад байна.

Энэхүү баримт бичиг нь “Нийтлэг үндэслэл”, “Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн алсын хараа, эрхэм зорилго, зарчим”, “Мэдээлэл, харилцаа холбоо технологийн бодлогын тэргүүлэх чиглэл”, “Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн тэргүүлэх чиглэл”, “Төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат, төсөл хөтөлбөр, хяналт-шинжилгээ” гэсэн 5 үндсэн бүлэг холбогдох дэд гарчиг, заалтуудаас бүрдэж байна.

Нийтлэг үндэслэл бүлэгт Мэдээлэл, харилцаа холбоо технологийн дэлхийн чиг хандлага, Олон Улсын цахилгаан холбооны байгууллагын зорилт, манай улсын Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн өнөөгийн байдал, орчны үнэлгээ, тус салбарын 2000-2010 он хүртлэх төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэнд хийсэн хяналт шинжилгээ зэргийг судлан, Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбоо, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын үндэслэлийг гаргахыг зорьсон болно. Түүнчлэн Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн алсын хараа, эрхэм зорилго, баримтлах зарчимд төрөөс баримтлах аливаа бодлогын баримт бичгийн уламжлалт утга санааг илэрхийлэхийн зэрэгцээ **“Мэдээлэл, харилцаа холбооны технологийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 21 дүгээр зууны үндсэн хурдасгуур гэж үзнэ”** гэсэн Цогц бодлогын зорилттой уялдуулан тодорхойлов.

Мэдээлэл, харилцаа холбоо технологийн бодлогын тэргүүлэх чиглэл бүлэгт үндэсний хэмжээнд Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн өнөөгийн өсөн нэмэгдэж байгаа цараа, хамрах хүрээ, хэрэгцээ шаардлагыг бүрэн хамруулах зорилгоор бодлогын тэргүүлэх чиглэлүүд тэдгээрийн тус бүрийн бодлогын томъёолол, стратегийн зорилго, үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойлсон нь энэхүү бодлогын баримт бичгийн онцлох шинэлэг хандлага бөгөөд Гадаад орнуудад мэдээлэл, харилцаа холбоо, технологийн талаарх бодлогоо тодорхойлсон жишиг баримт бичгүүдтэй нийцэж байгаа гэж үзэж байна.

Эхний бүлгүүдэд Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэгцээ шаардлагагыг тодорхойлсон бол “Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн тэргүүлэх чиглэл ” гэсэн бүлэгт энэхүү тэргүүлэх чиглэлүүдийг хангахад Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн үйлчилгээ, хамрах хүрээ, сүлжээ тэдгээрт шаардлагатай хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн зохицуулалт, бодлого зохицуулалтын байгууллагын бүтэц тогтолцооны талаарх төрийн бодлогыг тодорхойллоо.

Төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат, төсөл хөтөлбөр, хяналт-шинжилгээ гэсэн бүлэгт өмнөх бүлгүүдийг стртатеги, үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх үе шат, авах арга хэмжээ, хэрэгжилтийн талаарх хяналт-шинжилгээг авч үзсэн бөгөөд бодлогын судалгаанд үндэслэн төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр, хугацааг нарийвчлан тусгасан “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Засгийн газар батлахаар Улсын Их Хурлын тогтоолд тусгаад байна.

Бодлогыг боловсруулахдаа ерөнхий зорилго, зорилтуудаас нарийвчилсан үйл ажиллагааны зорилтыг гарган, үйл ажиллагааны зорилтууд нь эргээд зорилго, зорилтуудын хэрэгжих баталгааг бүрдүүлэх харилцан уялдаа , эргэх холбооны зарчмыг баримталсан болно.

**Анхаарал тавьсанд
баярлалаа
таны асуулт, санал
зөвлөгөө ?**